



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/683

Булган сум

Гамшгаас хамгаалах, бэлэн байдлын урьдчилсан үзлэг явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1, 10.3.2, 10.3.3, 10.3.5, 10.3.6, 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.3, 32.1.7, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Ажлын хэсэг томилох тухай” А/660 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан гэрээний дагуу 2023 оны 10 дугаар сарын 09-18-ны өдрүүдэд “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг” 16 сум, 1 тосгоны хэмжээнд зохион байгуулагдах болсонтой холбогдуулан орон нутгийн гамшгаас хамгаалах бэлтгэл ажлыг хангуулах, урьдчилсан үзлэгийг 2023 оны 09 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

2. “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-ийн бэлтгэл ажлыг чанартай хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт, мэргэжлийн туслалцаа үзүүлэн удирдлага зохион байгуулалтаар хангаж үр дүнтэй явуулахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ш.Баасандорж)-д даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын урьдчилсан үзлэг зохион байгуулах ажлын хэсгийн зардал 1,846,120 (нэг сая найман зуун дөчин зургаан мянга нэг зуун хорь) төгрөгийг хавсралтаар баталж, шаардагдах хөрөнгийг Гамшгаас хамгаалах сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Л.Пүрэвчулуун)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/682 дугаар
 захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН
 БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Явах сумд	Зай хэмжээ	Шатахуун /литр/	Нэг бүрийн үнэ
1	2	3	4	5
1 дүгээр хэсэг				
1	Булган-Бүрэгхангай	80	Long-78 569км х 20л=112 л Масло 1 л	112л х 3550=397600 1.5л х17000=17000
2	Бүрэгхангай-Баяннуур	100		
3	Баяннуур-Дашинчилэн	30		
4	Дашинчилэн-Рашаант	70		
5	Рашаант-Гурванбулаг	72		
6	Гурванбулаг-Могод	85		
7	Могод-Хишиг-Өндөр	50		
	Хишиг-Өндөр-Орхон	60		
	Орхон-Булган	22		
	Дүн	569км		414600
2 дугаар хэсэг				
1	Булган-Сайхан	100	Hanter 600км х 20=120 л Масло 1 л	120л х 2520=302400 1.5л х17000=17000
2	Сайхан-Баян-Агт	60		
3	Баян-Агт- Хутаг-Өндөр	110		
4	Хутаг-Өндөр-Тэшиг	90		
5	Тэшиг-Булган	240		
	Дүн	600км		319400
3 дугаар хэсэг				
1	Булган-Бугат	50	Land-200 287км х 20=56 л Масло 1,5 л	56л х 2520=141120 1л х17000=17000
2	Бугат-Сэлэнгэ	80		
3	Сэлэнгэ-Хялганат	27		
4	Хялганат-Хангал	30		
5	Хангал-Булган	100		
	Дүн	287км		158120
	Нийт	1456 км		892120
	Томилолт	өдөрт 1 хүн х 26500х4 хоног=106000 9 хүн х 4 өдөр=954000		954000
	Бүгд дүн			1846120